



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 2/51

Булган

Ажлын хэсэг байгуулах тухай

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны VI хуралдааны 06/06 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албан хэрэгцээнд шаардлагатай автомашин нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Буманбаяр - Аймгийн Засаг даргын Тамгын Газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Дэлгэрнамжил - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Г.Болдбаатар - Цагдаагийн газрын захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Ц.Даваадорж - Булган сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Д.Уламбаяр - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Буманбаяр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ

